

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАЛААРХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

“ENFORCEMENT OF ADMINISTRATIVE COURT DECISIONS THROUGH COMPULSORY EXECUTION”



Я.Батгэрэл

*Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны
403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны
сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн
профессор, доктор (Ph.D), хурандаа*

Товч агуулга: Хүний эрхийн түгээмэл тунхаглал²¹-ын 7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй”, 10 дугаар зүйлд “хараат бус, тал хардаггүй шүүхээр шүүлгэх эрхтэй” гэж зааснаас үзвэл, шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрхийн агуулга нь иргэдээ ялгаварлан гадуурхдаггүй, алагчилдаггүй, тал засдаггүй шүүхээр эрхээ хамгаалуулах тухай ойлголт юм.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн эх сурвалж нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон Монгол Улсын Үндсэн хууль²², түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж байхаар тогтоосон. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт²³-ын 14 дүгээр зүйлийн 1-д “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлохдоо хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй”, Монгол Улсын Үндсэн хуулийн далдугаар зүйлд “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино²⁴” хэмээн баталгаажуулжээ.

²¹ НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A III тогтоолоор батлагдсан.

²² Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1. 1992.

²³ НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A XXI тогтоолоор батлагдаж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

²⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1. 1992.

Монгол Улсад Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсанаас хойш 20 жил болжээ. Тус шүүхийн шийдвэрийн биелэлт сүүлийн 10 жилийн дунджаар 55,7 хувь байгаа нь хангалтгүй, нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол хангагдахгүй байна. Иймд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгаан нөхцөл болон шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх замаар албадан гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг судлан дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг хөндөн, цаашид шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх талаар санал гаргахыг зорилоо.

Түлхүүр үг: Нийтийн эрх зүй, захиргааны байгууллага, албан тушаалтан, шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэгч, хууль зүйн хариуцлага, төлбөр төлөгч, үүрэг хариуцлага.

ҮНДСЭН ХЭСЭГ

Захиргааны хэргийн шүүх нь эрх тэгш бус субъектүүдийн хоорондын хууль ёсны ашиг сонирхлыг тэнцвэржүүлж, шийдвэрээрээ дамжуулан иргэн хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр үйл ажиллагаанаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангах гол институт юм. Захиргааны хэргийн шүүхийн гол зорилго бол захиргааны байгууллага албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас зөрчигдсөн хүний эрхийг сэргээн тогтоож, эдлүүлэх үүргээр илэрхийлэгддэг бол шийдвэр гүйцэтгэл нь энэ зорилгыг хангахад оршдог²⁵.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нэг талаас төр түүнийг төлөөлсөн захиргааны байгууллага, албан тушаалтан, нөгөө талаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн хүн, хуулийн этгээд байдгаараа бусад төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас ялгаатай бөгөөд хариуцагчийг эрх залгамжлагч төлөөлөхдөө шүүхийн шийдвэрээр тодорхойлсон нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн бүхэлд нь гүйцэтгэх үүрэг хүлээдгээрээ онцлог харилцааг үүсгэдэг. Захиргааны шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг захиргааны байгууллага болон албан тушаалтан гэж ангилах бөгөөд албан тушаалтан нь захиргааны байгууллагыг төлөөлж эрх зүйн харилцаанд оролцдог²⁶.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох захиргааны байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, хүн заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ²⁷. Түүнчлэн захиргааны хэргийн

²⁵ Чимид, Б. Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн, УБ., 2004. 42 дахь тал

²⁶ Батгэрэл, Я., Замбага, Б., Цэрэнханд, Э., Бат-Эрдэнэ, М. Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ., 2022. 14 дэх тал

²⁷ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №9

шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг хэргийн оролцогч, түүний эрх залгамжлагч биелүүлэх үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх нь хууль ёсны зарчмын суурь элементэд хамаарах бөгөөд "Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх" гэдэгт хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтнаас шүүхийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эрхгүй байдгаар тодорхойлогдоно²⁸. Энэхүү зарчим нь шүүхийн бие даасан байдлыг илтгэдэг ба зарим улсын хувьд хуульдаа тодорхой тусгаж хэрэгжүүлдэг.

Шүүх эрх мэдлийн нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдал нь шүүхээс гарч буй шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байхаас гадна заавал биелэгдэх (legitimate) шинжтэйд оршино. Хэрэв шүүхээс гарч буй шийдвэр биелэгдэхгүй тохиолдолд нийгэм, олон нийтийн дунд шүүхийн нэр хүнд унаж, итгэх итгэл алдарна.

Шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй. Шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд зориуд саад учруулсан этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заажээ.

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль тогтоомжийг дагаж мөрдөх хувь хүний үүргээ биелүүлэлгүй эрх зүйн хэм хэмжээ зөрчсөнийх нь төлөө хууль дээдлэх болон шударга ёсны зарчимд нийцүүлэн хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлага үүснэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны явцад үүссэн аливаа зөрчилд хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж тогтоож өгсөн.

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын онцлог нь хуулиар тусгайлан тогтоож өгсөн бөгөөд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол хариуцлагаас чөлөөлгөдөгт оршино. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй дэх хууль зүйн хариуцлагын төрөл, хэлбэр нь зөрчил гаргагч этгээдийн зөрчлийн шинж байдлаас хамааран янз бүр байх бөгөөд төрийн

²⁸ Амарсайхан, Ц. нар. "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 2008. 59 дэх тал.

албадлагын төрлийг үндэслэн захиргааны хариуцлага, эрүүгийн хариуцлага, иргэний эрх зүйн хариуцлага, сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шийдвэр гаргасан шүүхээс тухайн шийдвэрийг гүйцэтгэх хугацааг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш шийдвэрийн агуулга, хөндөгдөж байгаа эрх, ашиг сонирхлын онцлогоос хамааран тогтоож өгдгөөрөө бусад төрлийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанаас өөр байдаг онцлогтой. Түүнчлэн захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг өөрчлөх, хүчингүй болгох, төсвийн зориулалт бүхий мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах зэрэг албадах ажиллагааг явуулдаг.

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч (хариуцагч)-д шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацаа тогтоон өгч, тогтоосон хугацаанд сайн дураар биелүүлээгүй бол захиргааны шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэнэ.


Хариуцагч шүүхээс тогтоосон буюу шүүхийн мэдэгдэлд заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болох бөгөөд сунгасан хугацаанд биелүүлээгүй нөхцөлд хариуцагч этгээд хэн байхаас үл хамааран шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй талаар олон нийтэд мэдээлнэ.

Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа, эсхүл ахлах шийдвэр гүйцэтгэгчийн сунгасан хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд захиргааны шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдэл хүргүүлж, шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллаагүй доод шатны албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, авсан арга хэмжээний талаар эргэж мэдэгдэхийг үүрэг болгоно. Шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдэлд заасан үүргийг хэрэгжүүлээгүй хүн, хуулийн этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх талаар тодорхой тусгасан байхыг шаарддаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтэд Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга доод шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавьж ШШГБ-тай харилцан хамтран ажиллах үүрэг хүлээсэн байдаг.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төлбөр төлөгч (хариуцагч) нь төрийн байгууллага, албан тушаалтан байдгаас шалтгаалан иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас илүү урт хугацаа шаардагдсан ажиллагаа байсаар ирсэн. Нийтийн эрх, ашгийг хангах, хамгаалах чиг үүргийн хувьд төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй, зогсолтгүй явах учиртай.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл гэж үзэж болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг бодит байдлаар сэргээхэд оршдог²⁹. Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа гүйцэтгэх баримт бичгийн биелэлтийн судалгааг сүүлийн 10 жилийн байдлаар дэлгэрэнгүй авч үзвэл дунджаар 55,7 хувь нь биелэгдсэн, 44,3 хувь нь биелэгдээгүй байна.



Зураг 1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийн талаарх судалгаа (2015-2024 он) “Эх сурвалж: ШШГЕГ-ын 2015-2024 оны тайлан, мэдээ”

2024 оны 10 сарын байдлаар захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй 7,569,891.0 төгрөгийн үнийн дүнтэй 417 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 885,823.1 төгрөгийн үнийн дүнтэй 175 гүйцэтгэх баримт бичгийг бүрэн дуусгаж 6,684,068.0 төгрөгийн 242 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна. Мөн 19 гүйцэтгэх баримт бичгийн 159,035.6 төгрөгийг хэсэгчлэн төлүүлжээ. Мөнгөн дүнгийн бодит биелэлт 11,7%, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 42% байна³⁰. Тухайлбал, шүүхийн шийдвэр биелүүлээгүй 223 төлбөр төлөгч байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр бүрэн гүйцэт биелэгдэж байх нь эрх зүйн соёл, ухамсрын түвшин харилцан адилгүй олон нийтийн зүгээс Захиргааны хэргийн шүүхийг хүлээн зөвшөөрөхөд чухал ач холбогдолтой юм³¹.

²⁹ Дугармаа, А. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол практикийн асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл.

³⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны тайлан мэдээ.

³¹ Жамъяанпүрэв, Э. “Захиргааны шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэл. //Иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл: илтгэлийн эмхэтгэл. УБ., 2021. 117 дахь тал.

Өөрөөр хэлбэл Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээс шууд хамааралтай байдаг онцлогтой.

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны талаарх судалгааг харьцуулан авч үзэхэд бүх шатны Засаг дарга, түүний Тамгын газар 36.3 хувь, төрийн яам, Сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга 20.6 хувь, Засгийн газрын агентлаг 15.7 хувь буюу дээрх байгууллагууд биелэгдээгүй гүйцэтгэх баримт бичгийн 72,6 хувийг эзэлж байна.

Д/д	Захиргааны байгууллага	Биелүүлээгүй	Үүнээс ажиллагаа явагдаж байгаа хугацаа												Эзлэх хувь
			2024	2023	2022	2021	2020	2019	2018	2017	2016	2015	2014	2013	
1	Засгийн газар, ХЭГ	10	2	2	5				1						4.5
2	Яам, сайд, ТНБД	46	18	8	7	6		2	2	1	1		1		20.6
4	Бүх шатны засаг дарга, ТГ	81	28	20	9	7	4	3	3	1	1	1	0	4	36.3
5	Бүх шатны ИТХ	9	4	2	1	1	1	0	0	0	0	0	0	0	4.0
7	Засгийн газрын агентлагууд	35	17	5	7	0	3	1	0	1	0	0	1	0	15.7
8	НЗД-ын харьяа байгууллагууд	21	13	4	2	0	1	0	0	0	0	0	1	0	9.4
9	Бусад захиргааны байгууллага	21	13	4	2	0	1	0	0	0	0	0	1	0	9.4
	НИЙТ	223	95	45	33	14	10	6	6	3	2	1	4	4	

Хүснэгт 1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдийн талаарх судалгаа (2013-2024 он) “Эх сурвалж: ШШГЕГ-ын 2013-2024 оны тайлан, мэдээ”

Төрийн байгууллага, алба хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг барагдуулах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008-2023 оны төсөвт тусгагдсан мөнгөн хөрөнгөөс шүүхийн шийдвэрийг үндэслэн 72.6 тэрбум төгрөгийг төлбөр авагч иргэн, хуулийн этгээдэд олгосон байна.

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ³²” гэж, 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана³³” гэж тус тус заасан. Төрийн албаны зөвлөл 2024 онд 35 төлбөр төлөгчид холбогдох 350,035.6

³² Төрийн мэдээлэл эмхэтгэл Уб., 2018. №1

³³ Төрийн албаны тухай хууль. Уб., 2018. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1

төгрөгийг албадан гаргуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ханджээ.

Хариуцлага хүлээлгэх үндэслэл:

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны явцад зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан Эрүүгийн хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага оногдуулна. Зөрчил үйлсэн хүн, хуулийн этгээдийг үүргээ биелүүлээгүйтэй нь холбогдуулан ял, шийтгэл оногдуулсан нь уг үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Захиргааны хариуцлага: Зөрчлийн тухай хуульд зааснаар “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, зөрчлийн тухай хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ³⁴”. Хүн хуулийн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх харилцааны явцад шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх боломжтой ч түүнийг биелүүлэх, хангах талаар зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэн гэж үзнэ. Зөрчилд хүлээлгэх хуулийн хариуцлага нь шийтгэл юм. Шийтгэлийн зорилго нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны явцад хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино.

Зөрчлийн тухай хуульд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны явцад хүн, хуулийн этгээдээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн дараах зөрчлүүдэд хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.

1. Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах. /15.2 дугаар зүйл/ Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан, үйл ажиллагаанд нь саад учруулсан, шийдвэр гүйцэтгэгчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Энэ зүйлд заасан хариуцлагыг захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх үндэслэлтэй байна.

2. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх. /15.27 дугаар зүйл/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус иргэн, хуулийн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдэх хуудсаар хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний

³⁴ Зөрчлийн тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Энэ хариуцлагыг захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус, төлбөр төлөгчийн дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдэх хуудсаар хүлээлгэсэн үүргийг зөрчсөн тохиолдолд оногдуулах үндэслэлтэй.

Эрүүгийн хариуцлага: Эрүүгийн хууль зөрчсөн зан үйлтэй холбогдон үүсэх хууль зүйн үр дагаврыг эрүүгийн хариуцлага гэнэ³⁵.

Эрүүгийн хууль³⁶-ийн 1 дүгээр зүйлийн 1.3-т “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гээд эрүүгийн хариуцлагын зорилгыг “Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино” хэмээн тодорхойлжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны явцад эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлд заасан. Энэ нь иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны явцад үүссэн гэмт буруутай үйлдэл, эс үйлдхүй байхаар хуульчилсан байна. Эрүүгийн хуульд заасан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэрэг” түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зохицуулалт нь шүүхийн шийдвэр үл биелүүлсэн этгээдэд тэр дундаа захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх боломжгүй байна.

Сахилгын хариуцлага: Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.2 дахь хэсэгт “Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдэл хүргүүлнэ” гэж сахилгын хариуцлага оногдуулах үндэслэлийг зааж өгчээ.

³⁵ Эрдэнэбат, Г. Эрүүгийн эрх зүй /гарын авлага/. Уб., 2007.,121 дэх тал.

³⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл Уб., 2016. №7.

Төрийн албаны тухай хуульчийн 48 дугаар зүйлийн 8 дахь хэсгээр зөвхөн төрийн жинхэнэ албан хаагч гэж заасан нь улс төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг хязгаарласан явдал юм³⁷.

Түүнчлэн мөн хуулийн 76 дугаар зүйлийн 76.4 дэх хэсэгт “Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн 76.7-д зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ”, 76.5 дахь хэсэгт “энэ хуулийн 76.4-д заасан эрх бүхий этгээд нь мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар 7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ”, 76.6 дахь хэсэгт “энэ хуулийн 76.4, 76.5-д заасныг зөрчсөн эрх бүхий этгээдийг төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас хална”, 76.7 дахь хэсэгт “энэ хуулийн 76.4-т заасан хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгох үүрэгтэй” гэж тус тус заасан бөгөөд энэ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай.

Иргэний эрх зүйн хариуцлага: ШШГТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэгт “Захиргааны байгууллагын дансанд байгаа мөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд төлбөрийг дараагийн жилийн төсөвт тусгаж, барагдуулах бөгөөд Захиргааны байгууллага төлбөрийг дараагийн жилийн төсөвт тусгаж, барагдуулаагүй бол нэхэмжлэгч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтан болон төрөөс өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй” гэж иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тогтоожээ.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн талаар: ШШГБ 2023 онд шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн 87 этгээдэд эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр цагдаагийн байгууллагад хандсан байна. Үүнээс 70 этгээдэд холбогдох материалд нотлох баримт дутуу, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх шалтгаанаар эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэж, 17 төлбөр төлөгчид холбогдох гомдол хянагдаж байна.

³⁷ Батчимэг, Б. “Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл. УБ., 2023. Төрийн албатай холбоотой захиргааны хэргийг шүүхийн шийдвэр түүний хэрэгжилтийг хангахад тулгамдаж буй асуудал. 103 дахь тал.

Зураг 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэргийн судалгаа (Эрүүгийн хуулийн 21.7-р зүйл) “Эх сурвалж: ЦЕГ-ын судалгаа”

Цагдаагийн байгууллагад 2023 онд эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлд заасан 30 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 9 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж 21 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэжээ.




Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага тооцуулахаар Цагдаагийн байгууллагад хандаж байгаа боловч холбогдох материалд нотлох баримт дутуу, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэжээ. Мөн эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр хандсан хугацаанд 2020 онд 5 төлбөр төлөгч, 2021 онд 4 төлбөр төлөгч төлбөрөө бүрэн төлж барагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэд үр нөлөө үзүүлж байна гэж үзлээ.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тохиолдол байхгүй байгааг энэ төрлийн зөрчлийг эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцоогүйтэй холбон тайлбарлах нь зүйтэй.

Захиргааны хариуцлага хүлээлгэсэн талаар: Зөрчлийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан, ахлах шийдвэр гүйцэтгэгч мөн хуулийн 6.20 дугаар зүйлийн 6.20.6 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 15.2.2 дахь хэсэг, 15.27 дугаар зүйлд заасан үндэслэлээр зөрчлийн хэрэг үүсгэн шалгах эрхтэй.

Эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуульд заасан эрхээ хэрэгжүүлж зөрчил шалган шийдвэрлэн шийтгэл оногдуулсан талаарх мэдээг нэгтгэвэл:



Зураг 3. Зөрчлийн шийтгэл оногдуулсан судалгаа (сүүлийн 7 жилийн байдлаар)
“Эх сурвалж: ШШГЕГ-ын мэдээ”

ШШГБ-ын хэмжээнд 2023 онд 60 гомдол, мэдээлэл хүлээн авч 12 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг үүсгэхээс татгалзаж 11 этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр шалгалтын ажиллагаа явуулж 9.8 сая төгрөгөөр, 8 этгээдэд мөн хуулийн 15.27 дугаар зүйлд заасан үндэслэлээр шалгалтын ажиллагаа явуулж 4.1 сая төгрөгөөр, 9 этгээдэд мөн хуулийн 6.20 дугаар зүйлд заасан үндэслэлээр шалгалтын ажиллагаа явуулж 900 мянган төгрөгөөр торгох шийтгэл, 19 төлбөр төлөгчид баривчлах шийтгэл оногдуулжээ.

Сахилгын хариуцлага хүлээлгэсэн талаар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.2 дахь хэсэгт “Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдэл хүргүүлнэ” гэж заасан хэдий ч шүүхийн шийдвэр биелүүлээгүй албан тушаалтанд сахилгын хариуцлага оногдуулаагүй байна.

Хэдийгээр ШШГБ шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр Цагдаагийн байгууллагад холбогдох материалыг хүргүүлэх, ахлах шийдвэр гүйцэтгэгч зөрчлийн хэрэг үүсгэн, шалган шийдвэрлэж байгаа боловч захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэсэн тохиолдол байхгүй байна.

Харьцуулсан судалгааны талаар:

Гадаадын зарим улсын хууль тогтоомжид тусгагдсан шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэж буй хууль зүйн хариуцлагын харьцуулсан судалгааг хийхдээ хөрш орнууд болох Оросын холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, эрх зүйн хөгжил өндөртэй Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Шведийн Хаант Улс, Испанийн Хаант Улс, Ази тивийн төлөөлөл болох Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, 1991 оноос тусгаар тогтнолоо зарласан Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Молдов Улсыг сонгон судаллаа.

Улсын нэр	Хүлээлгэх эрүүгийн хариуцлага
ОХУ	Төрийн алба хаагчид, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл тэдгээрийг биелүүлэхэд саад учруулсан бол 200.000 хүртэл рубль эсхүл ялтны 18 сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах эсхүл 2 жил хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл 6 сар хүртэлх хугацаагаар баривчлах эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
БНХАУ	Ардын шүүхийн шийдвэр, магадлалыг гүйцэтгэх чадвартай хэр нь биелүүлэхээс татгалзсан хүнд нөхцөл байдал хүнд бол 3 жилээс илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.
ХБНГУ	Шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд саад учруулсан бол 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хөнгөрүүлэх нөхцөл байдал байвал 3 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл мөнгөн торгууль оногдуулдаг байна.
Швед	Төрийн албан хаагчийг эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь саад учруулах, эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь өшөө авах зорилготой үйлдлийг зүй бусаар үйлдсэн төрийн албан хаагчийг хохироосон, эсхүл танхайрсан бол 6 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэдэг байна.
Испани	Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, эсхүл шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд саад учруулсан эрх бүхий байгууллага, төрийн албан тушаалтныг 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар баривчлах, 3-8 сар хүртэл хугацаагаар торгох, ажил, албан тушаалыг нь 1-3 жилийн хугацаатай түдгэлзүүлэх ял шийтгэнэ.
Япон	Албадан гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хууран мэхлэх арга буюу хүч хэрэглэн хилээр нэвтрэх, оргон зайлах үйлдэл хийсэн этгээдийг 3 жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсхүл хоёр сая 500 мянган иенээс дээшгүй хэмжээгээр торгох шийтгэл хүлээлгэнэ.
БНСУ	Төрийн албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үүргээ биелүүлэхээс татгалзсан, эсхүл үүргээ биелүүлээгүй бол түүнийг 1 жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсхүл мэргэшлийг нь 3 жилийн хугацаагаар түдгэлзүүлэх ял шийтгэдэг байна.
БНКУ	Хууль ёсны хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шүүхийн бусад акт, гүйцэтгэх баримт бичгийг албан тушаалтан албан тушаалаа ашиглан саад учруулсан бол тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасаж, 1200 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, 3-5 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах эсхүл 3-5 хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэдэг.
БНМУ	Албан тушаалтан хүн санаатайгаар биелүүлээгүй, эсхүл биелүүлэхээс зайлсхийсэн бол 650-850 хүртэл төлбөрийн нэгжээр торгох эсвэл 180-240 цаг хүртэл хугацаагаар цалин хөлсгүйгээр нийгэмд тустай хөдөлмөр

хийлгэх, эсвэл 2-5 жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял шийтгэнэ.


Хүснэгт 2. Гадаадын зарим оронд шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаа

Эдгээр улс орнууд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд дийлэнх тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг бөгөөд хорих ялыг 3 сараас 5 жилийн хугацаагаар оногдуулах, торгох ял, нийгэмд тустай ажил хийлгэх, баривчлах, эрх чөлөөг хязгаарлах, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах зэрэг ялаар шийтгэх эрх зүйн зохицуулалттай байна.

Шийдвэр гүйцэтгэгч нараас авсан судалгааны үр дүнгийн талаар:

Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэхэд учирч байгаа хүндрэл, бэрхшээл, анхаарах асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг боловсруулах зорилгоор нийслэл, орон нутгийн 42 ахлах шийдвэр гүйцэтгэгч болон 95 шийдвэр гүйцэтгэгчээс анкетын арга ашиглан санал асуулга авч өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийлээ.

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэхэд шийдвэр гүйцэтгэгчид тулгамддаг асуудлыг тодруулахад ажлын ачааллын нөлөө маш их гэж 43.2 хувь, их гэж 37.9 хувь, бага гэж 14.7 хувь огт үгүй гэж 4.2 хувь үзсэн бол нотлох баримт бүрдүүлэхэд маш их төвөгтэй гэж 26.3 хувь, их төвөгтэй гэж 33.7 хувь, бага гэж 28.4 хувь огт төвөггүй гэж 11.6 хувь тус тус үзсэн байна.



Зураг 4. Хууль зүйн хариуцлага хүлээлгэхэд шийдвэр гүйцэтгэгч нарт тулгамдсан асуудал.

Мөн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэж байсан туршлагатай эсэхийг тодруулах зорилгоор асуусан туршлага байна уу гэсэн асуумжид маш бага гэж 13.7 хувь, туршлага бага гэж 32.6 хувь, туршлагатай гэж 33.7 хувь, маш их туршлагатай гэж 20 хувь хариулсан. Шийдвэр гүйцэтгэгч нарын шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх талаар хууль зүйн мэдлэг хэр байгааг тодруулахад хууль зүйн мэдлэг

маш сайн гэж 18.9 хувь, сайн гэж 51.6 хувь, бага гэж 21.1 хувь, хариуцлага хүлээлгэх талаар мэдлэггүй гэж 8.4 хувь үзсэн байна.

Судалгааны дүнгээс харахад шийдвэр гүйцэтгэгч нарын 60 орчим хувь нь шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх талаар хууль зүйн мэдлэгтэй, хариуцлага хүлээлгэж байсан туршлагатай байна. Дийлэнх нь төлбөр төлөгчид хариуцлага хүлээлгэдэггүй шалтгаанаа ажлын ачаалал их болон хариуцлага хүлээлгэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд саналаа хүргүүлэх, нотлох баримт бүрдүүлэхэд төвөгтэй байдаг гэж үзжээ.

Бидний хийсэн судалгааны “захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд ямар хүндрэл учирч байна вэ?” гэсэн асуулгад 44.3 хувь нь Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх хууль эрх зүйн орчин дутагдалтай байдаг гэж хариулсан нь анхаарал татаж байна.

Шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог хэрхэн үзэж байна вэ гэсэн асуултад хариуцлага сул гэж 50 хувь, сайжруулах шаардлагатай гэж 32 хувь, сайн мэдэхгүй байна гэж 14 хувь, хариуцлага хангалттай гэж 4 хувь нь үзсэн бол Таны бодлоор шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгчид эрүүгийн хариуцлага /хорих ял/ хүлээлгэдэг болбол төлбөр төлөх байдал нэмэгдэх үү? гэсэн асуултад 82 хувь нь хариуцлага хүлээлгэдэг болчихвол үүргээ биелүүлэх байдал сайжирна гэж, 10 хувь нэмэгдэхгүй гэж, 8 хувь сайн мэдэхгүй гэж хариулсан нь шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эергээр нөлөөлнө гэж үзжээ.

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлагын төрлөөс алийг хүлээлгэх нь зүйтэй вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын дийлэнх олонх буюу 59 хувь эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үр нөлөө үзүүлнэ гэж үзсэн бол 24 хувь нь захиргааны хариуцлага, 12 хувь нь сахилгын хариуцлага, 5 хувь нь иргэний хариуцлага хүлээлгэх зүйтэй гэж үзжээ.

ДҮГНЭЛТ:

Захиргааны хэргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын талаар судлан дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль тогтоомжийг дагаж мөрдөх хувь хүний үүргээ биелүүлэлгүй эрх зүйн хэм хэмжээ зөрчсөнийх нь төлөө хууль дээдлэх болон шударга ёсны зарчимд нийцүүлэн хууль зүйн хариуцлага хүлээлгэх хэрэгцээ шаардлага үүсчээ. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Төрийн албаны хуульд заасан сахилгын хариуцлага хүлээлгэхээр санал хүргүүлэх төдийгөөр хязгаарлан хууль дээдлэх зарчим, шударга ёсны зарчмыг хангахгүй нийгмийн зөрчилдөөний

онолын хүрээнд ялгамжтай хандсан байх тул шүүхийн шийдвэр биелүүлээгүй албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй.

2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт байхгүй, захиргааны хариуцлага буюу зөрчлийн шийтгэл оногдуулах эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч төдийлөн үр нөлөө үзүүлэхгүй байгаа нь холбогдох хуульд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт оновчтой биш байгаагаас үүсжээ. Эрүүгийн хуульд заасан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэрэг” түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зохицуулалт нь өмнөх эрх зүйн зохицуулалтын уламжлал, чиг хандлагаас ухарсан, шүүхийн шийдвэрийг санаатайгаар биелүүлэхгүй байгаа этгээдэд хариуцлага тооцох боломжгүй болсон байгааг Эрүүгийн хуульд нэмэлт оруулах замаар эрүүгийн хариуцлагын үр нөлөөг дээшлүүлэх, ШШГТ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар төлбөр төлөгчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзлээ.

3. ШШГЕГ-аас шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг багасгах, тэнцвэржүүлэх, орон тоог нэмэгдүүлэх, ажлын байрны болон ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг сайжруулахад чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх, шийдвэр гүйцэтгэгч нарт хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын шатанд нотлох баримт бүрдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах зэрэг зохион байгуулалтын оновчтой арга хэмжээ авах замаар дээрх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

4. Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн этгээдэд заавал хариуцлага тооцдог механизмыг бүрдүүлэх, энэ талаарх алба хаагчдын мэдлэг, чадвар, хандлагыг дээшлүүлэх, сургалтыг тогтмол зохион байгуулах, гадаадын зарим улсын үр дүнтэй сайн туршлагаас өөрийн орны эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн нутагшуулах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

САНАЛ:

Энэхүү судалгааны ажил, дүгнэлтэд тулгуурлан шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх ажиллагааны үр нөлөөг сайжруулахтай холбоотой дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

1. Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлийг дараах байдлаар шинэчлэн найруулах:

Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан,

бусдад шилжүүлсэн, үрэгдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг санаатай биелүүлээгүй, дүр эсгэн биелүүлсэн, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан, шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хоёр. Үйл ажиллагаа, зохион байгуулалтын хүрээнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг сайжруулахад чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх, туршлага бүхий шийдвэр гүйцэтгэгч нараас бүрдсэн ажлын хэсгээр он удаан жил шийдвэрлээгүй гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах,

2. Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх ажиллагааг тогтмол явуулах, шийдвэр гүйцэтгэгч нарт хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын шатанд нотлох баримт бүрдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
4. Эрүүгийн хууль 2015 он
5. Зөрчлийн тухай хууль 2017 он
6. Төрийн албаны тухай хууль 2018 он

Олон улсын гэрээ:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 он

Ном гарын авлага:

1. Чимид, Б. Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн, Уб., 2004.
2. Батгэрэл, Я., Замбага, Б., Цэрэнханд, Э., Бат-Эрдэнэ, М. Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. Уб., 2022.

3. Амарсайхан, Ц. нар. "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 2008.
4. Дугармаа, А. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол практикийн асуудал" сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл.
5. Батчимэг, Б. "Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл. УБ., 2023. Төрийн албатай холбоотой захиргааны хэргийг шүүхийн шийдвэр түүний хэрэгжилтийг хангахад тулгамдаж буй асуудал. 103 дахь тал.

Цахим эх сурвалж:

1. <https://www.criminology.mn>
2. <https://www.legalinfo.mn>
3. <https://cd.gov.mn/>

Бусад эх сурвалж:

1. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны мэдээ, тайлан.
2. Legal liability imposed on convicts who evade punishment in the form of travel restriction

---o0o---